

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ГАМШГААС ХАМГААЛАХ ТҮР ШТАБЫН ХУРЛЫН ШИЙДВЭР

2021 оны 06 дугаар
сарын 13-ны өдөр

№ 15

Улаанбаатар хот

Иргэний нисэхийн ерөнхий газрын гамшгаас хамгаалах түр штабын 15 дугаар хурлыг 2021 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 19 цаг 00 минутад цахимаар зохион байгуулав. Тус хуралд ИНЕГ-ын дэд дарга Б.Алтанцом, ИНЕГ-ын гамшгаас хамгаалах түр штабын гишүүд болон ИНҮТ-ийн дарга П.Мөнхжаргал, дэд дарга Н.Мягмарсүрэн, тус төвийн гамшгаас хамгаалах штабын гишүүд тус тус оролцов.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Улс орон даяар коронавируст халдварын “батлагдсан тохиолдол” нэмэгдсээр, халдварын тархалт буурахгүй байгаа тул үйл ажиллагааг шуурхай зохион байгуулан, байгууллагын хэмжээнд халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулах талаар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл ИИЦГ болон ИИҮТ-ийн өдрийн 8 цагаар ажиллах нийт ажилтнуудын 30 хүртэлх хувийг ажлын байранд ажиллуулах, ээлжийн зохион байгуулалтын ажиллах ажилтнуудыг ажлын байрны халдвар хамгааллын дэглэмийг сайтар мөрдүүлж, хүн хооронд зай барьж суулгаж ажиллуулах ажил үүргийн хуваарилалтыг хийж батлуулах, зөвхөн хуваарийн дагуу ажилтнуудыг байгууллага руу нэвтрүүлэхийг бүх газар, харьяа салбар нэгжийн дарга нарт;

2. Жирэмсэн болон 0-12 насны хүүхэдтэй эх, 0-12 хүртэх насны хүүхэдтэй ганц бие эцэг, 50-аас дээш настай эмэгтэй, 55-с дээш настай эрэгтэй, архаг хууч өвчтэй болон вакцины эсрэг заалттай ажилтнуудыг зайнаас ажиллуулах нөхцөл боломжийг бүрдүүлэхийг Захиргаа, удирдлагын газар /Т.Батжаргал/, Иргэний нисэхийн үндэсний төв /П.Мөнхжаргал/-д;

3. “Буянт-Ухаа” ОУНБ-ын нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагааг нүүлгэн шилжүүлэх, “Чингис Хаан” ОУШНБ-ын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд төлөвлөгдсөн ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцогч харьяа салбар, нэгжийн ажилтнууд болон “Нүүлгэн шилжүүлэх удирдлагын төв”-ийн гишүүдийн халдвар хамгааллын дэглэмийг сайтар мөрдүүлэх, ажлын байр, өрөө, тасалгаа, заал, танхимуудад ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийлгэж, автобусанд 1.5-2 метрийн хүн хоорондын зайг баримтлан зорчуулахтай холбоотой зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Иргэний нисэхийн үндэсний төв /П.Мөнхжаргал/-д;

4. “Чингис Хаан” ОУНБ руу зорчих ажилтнуудаас коронавирусын халдвар илрүүлэх түргэвчилсэн тест авах, амны хаалт, гар халдваргүйжүүлэгч, бээлий, хог хаягдлын уут, бусад шаардлагатай халдвар хамгааллын хэрэгслээр хангах болон тээвэрлэлттэй холбогдон гарах зардлын тооцооллыг хийж, санхүүжилтийг шийдвэрлүүлэхийг Иргэний нисэхийн үндэсний төв /П.Мөнхжаргал/-д;

5. Ажлын байранд олон нийтийг хамарсан арга хэмжээ, хурал, семинар зохион байгуулахгүй байх, ажлын байрны дэг журам, сахилга батыг чанд сахиулах, ажил үүргийн хуваарилалтыг тодорхой болгож үр дүнтэй ажиллах, зайнаас ажиллах хугацаандаа гэрээс гарч олон нийтийн газраар явахгүй байх, сонор сэрэмжээ улам сайжруулж, хүн бүр дор бүрнээ хувийн хариуцлага, сахилга бат, ариун цэвэр, ахуйн дэглэмээ сахих үүргээ чандлан биелүүлэхийг нийт ажилтнуудад уриалах, мөн байгууллага руу гадна, дотноос

хүн нэвтрүүлэхгүй байх, зайлшгүй шаардлагаар нэвтрэх гадны байгууллагын ажилтнуудыг тусгайлан бэлтгэсэн уулзалтын өрөөнд хүлээн авах зохицуулалтыг хийхийг Иргэний нисэхийн ерөнхий газрын гамшгаас хамгаалах штаб /П.Ариунболд/, Иргэний нисэхийн үндэсний төвийн гамшгаас хамгаалах штаб /Д.Эрдэнэ-Очир/-т;

6. Ажлын байр, өрөө тасалгаа, үйлчилгээний заал танхимууд болон албаны тээврийн хэрэгсэлд ариутгал, халдваргүйжүүлэлтийг өдөр бүр хийлгэж, халдвар хамгааллын дэглэмийг сахиулахад шаардлагатай хэрэгсэл болон коронавируст халдвар илрүүлэх түргэвчилсэн тестийн нөөцийг тус тус бүрдүүлж, ашиглах, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Ч.Нямсүрэн/, Иргэний нисэхийн үндэсний төв /П.Мөнхжаргал/-д;

7. Ажлын байранд халдвар тархах эрсдэлийг бууруулах зорилгоор ажилтнуудаас коронавируст халдвар илрүүлэх антигенд суурилсан түргэвчилсэн тест авах хэрэгцээ шаардлага, давтамжийг тодорхой болгон журамлахыг Иргэний нисэхийн үндэсний төвийн гамшгаас хамгаалах штаб /Д.Эрдэнэ-Очир/-т;

8. Халдвар авсан мөн батлагдсан тохиолдлын ойрын хавьтал болсон ажилтнууд хариуцсан нэгжийн дарга, өөрийн харьяалах Гамшгаас хамгаалах штабт мэдэгдэх талаар нийт ажилтнууддаа дахин үүрэг болгохыг бүх газар, харьяа салбар, нэгжийн дарга нарт;

9. Ажилтнуудад үйлчлэх технологийн автомашин, автобусанд хүн хоорондын зай барьж зорчуулах болон ажилтнууд гуанз, цайны газруудаар үйлчлүүлж халдвар авах эрсдэлийг бууруулахтай холбоотой зохион байгуулалтын арга хэмжээг дотооддоо авах, мөн ажилтнууд үдийн цайгаа гэрээсээ авч ирж байхыг нийт ажилтнуудад уриалахыг Иргэний нисэхийн үндэсний төв /П.Мөнхжаргал/-д;

10. Цаашид халдварын нөхцөл байдал хүндрэх тохиолдолд үүссэн цагийн байдалтай уялдуулан хүч хэрэгслийн тооцоо, ажилтнуудын ажиллах хуваарь, нөөцийг оновчтой тооцон авч хэрэгжүүлэх арга хэмжээг нарийн төлөвлөн саналаа Зам, тээврийн хөгжлийн яамны гамшгаас хамгаалах штабт уламжлан, холбогдох шийдвэрийг гаргуулахыг Иргэний нисэхийн ерөнхий газрын гамшгаас хамгаалах штабын орлогч дарга /Г.Батбаяр/, Иргэний нисэхийн үндэсний төвийн гамшгаас хамгаалах штаб /Д.Эрдэнэ-Очир/-т;

11. "Ажилтнуудыг зайнаас цахимаар ажиллуулах түр журам"-ын төсөлд санал авч, батлуулахыг Захиргаа, удирдлагын газар /Г.Батжаргал/-т, үйл ажиллагаанд мөрдлөгө болгон журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг бүх газар, харьяа салбар, нэгжийн дарга нарт;

12. ИНЕГ-ын гамшгаас хамгаалах түр штабын хурлын шийдвэрүүдийн хэрэгжилт удаашралтай байгаа ажил, арга хэмжээг тус тусын чиг үүргийн дагуу эрчимжүүлэн хэрэгжилтийг ханган ажиллахыг бүх газар, харьяа салбар нэгжийн дарга нарт тус тус үүрэг болгов.

ГАМШГААС ХАМГААЛАХ ТҮР ШТАБЫН ДАРГА БӨГӨӨД
АННББЗГ-ЫН ДАРГА Д.ЭРДЭНЭБААТАР

